



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СБА-2025/132/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2025 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитор: Б.Бүзмаа

Утас: 91160110 Цахим хаяг: buzmaa@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

.....**Error! Bookmark not defined.**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... 5**

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 10**

**3.1 Зөвлөмж..... 10**

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 12**

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 168

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндэлгэр сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд эргэлтийн бус хөрөнгө 227.8 сая төгрөг. Үүнд 348.7 сая төгрөг анхны өртөг бүхий хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дансны үлдэгдэл 120.9 сая төгрөг байна. 37 ширхэг 27.1 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийг тайлан тодруулгад илэрхийлсэн байна.

### Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст буюу 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр БЯ-аас 134.4 сая төгрөгийн санхүүжилтийг цалин хөлс нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд хуваарилсан, үлдэгдэл 100.2 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээр тайлагнасан байна. Иймд боловсролын байгууллагын дээд шатны төсвийн захирагчийн цалингийн төсвийн төлөвлөлт, үлдэгдэлд дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

## **Бусад асуудал**

Цэцэрлэгийн барилгын багтаамж, чанар агааржуулалт муугаас 4 гэр цэцэрлэгийг нэмж ажиллуулсанаар нийт 257 хүүхдэд 9 бүлгээр сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явагдаж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>160,013,516.11</b>	<b>279,614,584.35</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	85,843,628.11	187,859,916.35
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	85,843,628.11	187,859,916.35
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	85,843,628.11	187,859,916.35
31211	Төрийн сангийн харилцах	85,843,628.11	187,859,916.35
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	74,169,888.00	91,754,668.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	74,169,888.00	91,754,668.00
35410	Бичиг хэргийн материал	403,400.00	2,519,500.00
35420	Аж ахуйн материал	73,033,228.00	88,536,228.00
35440	Түлш, шатах тослох материал	733,260.00	698,940.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>223,978,003.39</b>	<b>227,802,265.67</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	223,978,003.39	227,802,265.67
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	210,592,003.39	214,776,265.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	137,790,520.91	137,790,520.91
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,348,959.60	-37,618,751.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	86,618,600.00	101,718,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,632,756.83	-39,920,702.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,388,040.00	51,388,040.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,715,874.64	-17,272,874.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,196,406.00	42,196,406.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-18,168,072.45	-24,969,072.33
39217	Ном	1,464,100.00	1,464,100.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,386,000.00	13,026,000.00
39301	Програм хангамж	1,800,000.00	1,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-740,000.00	-1,100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,326,000.00	12,326,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>383,991,519.50</b>	<b>507,416,850.02</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,364,000.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,364,000.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,364,000.00	-
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,500,000.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	864,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	864,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>381,627,519.50</b>	<b>507,416,850.02</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	381,627,519.50	507,416,850.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,000,000.00	6,000,000.00
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрийн сан	6,000,000.00	6,000,000.00
51101	Өмч: - төрийн	113,972,900.00	113,972,900.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	107,069,700.57	232,859,031.09
51210	Өмнөх үеийн үр дүн	-751,833.52	107,069,700.57
51220	Тайлант үеийн үр дүн	107,821,534.09	125,789,330.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	154,584,918.93	154,584,918.93
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>383,991,519.50</b>	<b>507,416,850.02</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,004,205,200.00</b>	<b>1,351,138,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>62,746,100.00</b>	<b>49,710,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	62,746,100.00	49,710,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,746,100.00	49,710,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	62,746,100.00	49,710,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>941,459,100.00</b>	<b>1,301,428,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	893,996,600.00	1,249,305,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	893,996,600.00	1,249,305,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	47,462,500.00	52,123,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,312,500.00	52,123,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	150,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>896,383,665.91</b>	<b>1,225,349,169.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>896,383,665.91</b>	<b>1,225,349,169.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	876,734,714.98	1,223,973,566.53
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	562,538,926.76	866,731,245.57
210101	Үндсэн цалин	397,190,840.39	564,036,510.28
210102	Нэмэгдэл	138,671,368.07	263,745,885.29
210104	Урамшуулал	26,676,718.30	38,948,850.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	72,959,965.12	109,386,676.19
210201	Тэтгэврийн даатгал	49,414,482.03	74,865,769.12
210202	Тэтгэмжийн даатгал	5,793,405.48	8,859,138.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,826,114.13	4,429,519.15
210204	Ажилгүйдлийн даатгал	1,224,631.43	4,429,519.15
210205	Эрүүл мэндийн даатгал	11,701,332.05	16,802,730.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,715,889.07	47,259,317.05
210301	Гэрэл, цахилгаан	5,571,735.39	12,254,900.33
210302	Түлш, халаалт	33,780,101.68	32,232,416.72
210303	Цэвэр, бохир ус	2,364,052.00	2,772,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,768,141.82	-
210408	Бараа материал акталсны зардал	20,768,141.82	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	123,281,540.00	126,902,580.00
210502	Хоол, хүнс	123,281,540.00	126,902,580.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,500,000.00	4,707,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	4,707,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,483,000.00	1,439,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,483,000.00	1,439,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	49,487,252.21	67,546,847.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,045,440.00	29,305,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,448,400.00	3,526,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,993,412.21	34,715,737.72
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	19,648,950.93	1,375,602.95
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	19,285,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,285,600.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	363,350.93	1,375,602.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	363,350.93	1,375,602.95
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>107,821,534.09</b>	<b>125,789,330.52</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>107,821,534.09</b>	<b>125,789,330.52</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>941,459,100.00</b>	<b>1,301,428,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>941,459,100.00</b>	<b>1,301,428,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	893,996,600.00	1,249,305,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	893,996,600.00	1,249,305,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	47,462,500.00	52,123,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,312,500.00	52,123,000.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	150,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>858,242,271.88</b>	<b>1,197,982,211.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>858,242,271.88</b>	<b>1,197,982,211.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>838,593,320.95</b>	<b>1,196,606,608.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	562,538,926.76	866,731,245.57
210101	Үндсэн цалин	397,190,840.39	564,036,510.28
210102	Нэмэгдэл	138,671,368.07	263,745,885.29
210104	Урамшуулал	26,676,718.30	38,948,850.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	72,959,965.12	109,386,676.19
210201	Тэтгэврийн даатгал	49,414,482.03	74,865,769.12
210202	Тэтгэмжийн даатгал	5,793,405.48	8,859,138.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,826,114.13	4,429,519.15
210204	Ажилгүйдлийн даатгал	1,224,631.43	4,429,519.15
210205	Эрүүл мэндийн даатгал	11,701,332.05	16,802,730.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,449,149.07	45,747,397.05
210301	Гэрэл, цахилгаан	5,571,735.39	12,254,900.33
210302	Түлш, халаалт	34,513,361.68	30,720,496.72
210303	Цэвэр, бохир ус	2,364,052.00	2,772,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	121,005,540.00	126,902,580.00
210502	Хоол, хүнс	121,005,540.00	126,902,580.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,500,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	5,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,483,000.00	3,305,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,483,000.00	3,305,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,656,740.00	39,532,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,208,340.00	29,971,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,448,400.00	9,561,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,648,950.93</b>	<b>1,375,602.95</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	19,285,600.00	-

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,285,600.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>363,350.93</b>	<b>1,375,602.95</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	363,350.93	1,375,602.95
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>83,216,828.12</b>	<b>103,446,288.24</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,649,800.00</b>	<b>1,430,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,649,800.00</b>	<b>1,430,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,649,800.00</b>	<b>1,430,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,649,800.00	1,430,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-6,649,800.00</b>	<b>-1,430,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>76,567,028.12</b>	<b>102,016,288.24</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>9,276,599.99</b>	<b>85,843,628.11</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>85,843,628.11</b>	<b>187,859,916.35</b>

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	113,972,900.00	154,584,918.93	-751,833.52	267,805,985.41
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	113,972,900.00	154,584,918.93	-751,833.52	267,805,985.41
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	6,000,000.00	-	-	6,000,000.00
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	107,821,534.09	107,821,534.09
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	119,972,900.00	154,584,918.93	107,069,700.57	381,627,519.50
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	119,972,900.00	154,584,918.93	107,069,700.57	381,627,519.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	119,972,900.00	154,584,918.93	107,069,700.57	381,627,519.50
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	125,789,330.52	125,789,330.52
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	119,972,900.00	154,584,918.93	232,859,031.09	507,416,850.02

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,384,267,200.00	1,198,036,608.81
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,384,267,200.00	1,198,036,608.81
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,384,267,200.00	1,198,036,608.81
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,028,100,100.00	866,731,245.57
210101	Үндсэн цалин	694,778,100.00	564,036,510.28
210102	Нэмэгдэл	305,556,400.00	263,745,885.29
210104	Урамшуулал	27,765,600.00	38,948,850.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	117,872,200.00	109,386,676.19
210201	Тэтгэврийн даатгал	80,155,700.00	74,865,769.12
210202	Тэтгэмжийн даатгал	9,427,100.00	8,859,138.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,714,800.00	4,429,519.15
210204	Ажилгүйдлийн даатгал	4,714,800.00	4,429,519.15
210205	Эрүүл мэндийн даатгал	18,859,800.00	16,802,730.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,123,000.00	45,747,397.05
210301	Гэрэл, цахилгаан	12,850,000.00	12,254,900.33
210302	Түлш, халаалт	31,363,000.00	30,720,496.72
210303	Цэвэр, бохир ус	2,910,000.00	2,772,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	138,051,400.00	126,902,580.00
210502	Хоол, хүнс	138,051,400.00	126,902,580.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,307,600.00	3,305,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,307,600.00	3,305,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	44,812,900.00	40,962,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,245,000.00	31,401,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,567,900.00	9,561,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,384,267,200.00	1,300,052,897.05
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,384,267,200.00	1,300,052,897.05
122005	Орон нутгийн төсвөөс	1,301,428,500.00	1,300,052,897.05
132004	Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/	82,838,700.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	85,843,628.11
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	187,859,916.35

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар 2 зөвлөмж хүргүүлээ. Илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### 3.1 Зөвлөмж

##### 1. Илрүүлэлт:

Хүнсний бараа, материалыг 126.9 сая төгрөгөөр худалдан авахдаа хууль тогтоомжийн дагуу тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 (Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна), 31.2. (харьцуулалт), 31.3 дахь (гэрээ шууд байгуулах) зүйл заалттай нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлж, тайлагнах хяналтыг сайжруулан, тендер шалгаруулалтыг хуульд заасан аргуудын хүрээнд зохион байгуулж, гэрээ байгуулах үйл явцыг ил тод, хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах

##### 2. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 37 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 (Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2 (Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна), үүнд 6.2.1 (Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон), “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан тогтоох асуудлыг судлан, элэгдлээрээ бүрэн нөхөгдсөн хөрөнгийг ашиглалтын боломжит байдлыг харгалзан дахин үнэлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, Мөн шаардлагатай тохиолдолд Орон нутгийн өмчийн газартай зөвшилцөн данснаас хасах шийдвэрийг гаргуулах томъёолол бэлтгэн, санхүүгийн тайланд бодитой тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгөд үлдэх өртөггүй 37 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
126.9 сая төгрөгийн бараа материал тендер зарлалгүй худалдан авсан	1				1	
<b>Дүн</b>	<b>1</b>				<b>1</b>	
<b>Нийт дүн</b>	<b>1</b>				<b>1</b>	